АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Өлзийт сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2023/27-НА-СТА-ТШ3**



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор Г.Цог-Эрдэнэ<br>Утас: 7033-3019<br>Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.07 № 4
танай ______ -ны № ______ -т

ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ТҮГЖЖАВ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд Нутгийн удирдлагын байгууллагын 30 жилийн ой тохиосон байна.

### Аудитын гол асуудал

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ны "... сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай" 376 дугаар тогтоолын дагуу Өлзийт сумын ИТХ-ын 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 07 тоот тогтоолоор ажлын албаны бүтэц орон тоог баталсан. Тайлангийн жилд 3 орон тоотойгоор ажиллажээ.

### Бусад асуудлын хэсэг

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 90 хувьтай үнэлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

003020042

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **12,327.63** | **2,225.25** |
| **33** | **АВЛАГА** | 12,327.63 | 2,225.25 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 12,327.63 | 2,225.25 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,691,063.23** | **2,491,283.38** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,691,063.23 | 2,491,283.38 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,691,063.23 | 2,491,283.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 3,867,618.00 | 5,674,118.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (2,792,617.96) | (3,182,834.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,459,957.00 | 7,459,957.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,843,893.81) | (7,459,957.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,703,390.86** | **2,493,508.63** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,703,390.86** | **2,493,508.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,703,390.86 | 2,493,508.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,239,505.00 | 2,239,505.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,239,505.00 | 2,239,505.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (608,546.61) | 181,571.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (608,546.61) | (608,546.61) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 790,117.77 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 72,432.47 | 72,432.47 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,703,390.86** | **2,493,508.63** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **59,078,900.00** | **82,091,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **59,078,900.00** | **82,091,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 420,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 420,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 58,658,900.00 | 82,091,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 58,658,900.00 | 82,091,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **60,077,832.62** | **81,300,882.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **60,077,832.62** | **81,300,882.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 60,077,832.62 | 52,402,822.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 45,705,554.35 | 41,167,758.76 |
| 210101 | Үндсэн цалин | 45,705,554.35 | 30,717,626.76 |
| 210102 | Нэмэгдэл | - | 8,980,991.00 |
| 210104 | Урамшуулал | - | 1,469,141.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,574,438.41 | 5,201,383.88 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,876,725.25 | 3,548,814.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 424,428.29 | 413,167.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 339,542.61 | 330,533.86 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 163,713.56 | 82,633.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 770,028.70 | 826,234.66 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,486,700.00 | 2,700,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 201,500.00 | 200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,036,200.00 | 2,400,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 249,000.00 | 100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 200,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 1,492,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,492,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,111,139.86 | 1,840,879.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,224,000.00 | 834,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 969,500.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 917,639.86 | 1,006,279.85 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 28,898,059.74 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 23,953,200.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 17,640,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 6,313,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 4,944,859.74 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,944,859.74 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(998,932.62)** | **790,117.77** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | - |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(998,932.62)** | **790,117.77** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **59,078,900.00** | **82,091,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **59,078,900.00** | **82,091,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 420,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 420,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 58,658,900.00 | 82,091,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 58,658,900.00 | 82,091,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **59,078,900.00** | **80,284,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **59,078,900.00** | **80,284,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **59,078,900.00** | **51,386,440.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 45,549,500.00 | 41,167,758.76 |
| 210101 | Үндсэн цалин | 45,549,500.00 | 30,717,626.76 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | - | 8,980,991.00 |
| 210104 | Урамшуулал | - | 1,469,141.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,649,200.00 | 5,191,281.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,827,200.00 | 3,538,712.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 455,500.00 | 413,167.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 364,400.00 | 330,533.86 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 91,100.00 | 82,633.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 911,000.00 | 826,234.66 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,536,200.00 | 2,700,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 300,000.00 | 200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,036,200.00 | 2,400,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 200,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 1,492,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,492,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,144,000.00 | 834,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,224,000.00 | 834,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 920,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **28,898,059.74** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 23,953,200.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 17,640,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 6,313,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 4,944,859.74 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,944,859.74 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **1,806,500.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **1,806,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **1,806,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 1,806,500.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 1,806,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(1,806,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,239,505.00** | **72,432.47** | **(608,546.61)** | 1,703,390.86 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,239,505.00** | **72,432.47** | **(608,546.61)** | 1,703,390.86 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,239,505.00** | **72,432.47** | **(608,546.61)** | 1,703,390.86 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 790,117.77 | 790,117.77 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,239,505.00** | **72,432.47** | **181,571.16** | 2,493,508.63 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| **Эдийн засгийн ангилал** | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | Зөрүү | харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 82,091,000.00 | 77,146,140.26 | 4,944,859.74 | 93.98 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 80,231,000.00 | 75,339,640.26 | 4,891,359.74 | 93.90 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 56,277,800.00 | 51,386,440.26 | 4,891,359.74 | 91.31 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 45,549,500.00 | 41,167,758.76 | 4,381,741.24 | 90.38 |
| 210101 | Үндсэн цалин | 45,549,500.00 | 30,717,626.76 | 14,831,873.24 | 67.44 |
| 210102 | Нэмэгдэл | - | 8,980,991.00 | (8,980,991.00) | - |
| 210104 | Урамшуулал | - | 1,469,141.00 | (1,469,141.00) | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,693,700.00 | 5,191,281.50 | 502,418.50 | 91.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,871,700.00 | 3,538,712.18 | 332,987.82 | 91.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 455,500.00 | 413,167.33 | 42,332.67 | 90.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 364,400.00 | 330,533.86 | 33,866.14 | 90.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 91,100.00 | 82,633.47 | 8,466.53 | 90.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 911,000.00 | 826,234.66 | 84,765.34 | 90.70 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,700,000.00 | 2,700,000.00 | - | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 200,000.00 | 200,000.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,400,000.00 | 2,400,000.00 | - | 100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 100,000.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,500,000.00 | 1,492,800.00 | 7,200.00 | 99.52 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000.00 | 1,492,800.00 | 7,200.00 | 99.52 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 834,600.00 | 834,600.00 | - | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 834,600.00 | 834,600.00 | - | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,953,200.00 | 23,953,200.00 | - | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,953,200.00 | 23,953,200.00 | - | 100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 17,640,000.00 | 17,640,000.00 | - | 100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,313,200.00 | 6,313,200.00 | - | 100.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,860,000.00** | **1,806,500.00** | 53,500.00 | 97.12 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,860,000.00 | 1,806,500.00 | 53,500.00 | 97.12 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 221001 | Их засвар | 1,860,000.00 | 1,806,500.00 | 53,500.00 | 97.12 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 82,091,000.00 | 77,146,140.26 | 4,944,859.74 | - |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 82,091,000.00 | 77,146,140.26 | 4,944,859.74 | - |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 82,091,000.00 | 77,146,140.26 | 4,944,859.74 | - |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **3.00** | **3.00** | - | 100.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 1.00 | 1.00 | - | 100.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй, харин залруулагдаагүй нийт 528.3 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 528.3 мянган төгрөгт 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

### 3.1 Албан шаардлага

Тус байгууллагын 2022 оны бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн 1,492.8 мянган төгрөгийн зардлын зарцуулалт, бараа үйлчилгээний бусад зардлын 834.6 мянган төгрөгийн зарцуулалтыг тус тус анхан шатны баримтаар тулган шалгахад 378.3 мянган төгрөгийг хоолны зардалд, 150.0 мянган төгрөгийг буудлын зардалд нийт 528.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн хуулийн 4.1.6, 4.2.1, 12.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 2 нэр төрлийн 9,677.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.*

*Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.*

*Өгсөн зөвлөмж*: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж холбогдох арга хэмжээг авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өлзийт сумын ИТХ | 2 | 528.3 | - | - | 1 | 528.3 | 1 | 0 | - | - | - | - |